



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/90.

Арвайхээр сум

Зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Зохицуулалт хийх тухай” А/52 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ихэнх нутгаар цас их орсон, цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал бий болж өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч зудтай байгаа, 0-15 насны хүүхдийн дундаж томуугийн тархалт нэмэгдсэнтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/244 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтэц”-ийн 25 дахь 7 хоног буюу 2023 оны 02 дугаар сарын 20-ны даваа гарагийн танхимын хичээл сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 18-ны бямба гарагт, 2023 оны 02 дугаар сарын 24-ний баасан гарагийн танхимын хичээл сургалтыг 2023 оны 03 дугаар сарын 04-ний бямба гарагт тус тус шилжүүлэн зохион байгуулахыг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад, цэцэрлэгийн 2023 оны 02 дугаар сарын 20-ны даваа гарагийн танхимын хичээл сургалтыг 2023 оны 02 дугаар сарын 18-ны бямба гарагт шилжүүлэн зохион байгуулахыг цэцэрлэгийн эрхлэгч нарт тус тус зөвшөөрсүгэй.

2. Хичээл сургалтын үйл ажиллагааны зохицуулалтыг сургалтын хөтөлбөрийн агуулга хичээлийн жилийн үргэлжлэх хугацаанд бүрэн хэрэгжсэн байхаар зохион байгуулахад удирдлага, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Н.Чимэддорж-Ойдов)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0136

D:My Doc. Zahiramj. Zasag darga